

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ЧИГ, ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2022 оны 02 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар ...41

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8, Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоолыг тус тус үндэслэн төрийн байгууллагын зарим чиг, үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нэг талаас Сангийн яам, түүнийг төлөөлж Сангийн сайд Б.Жавхлан /цаашид “үүрэг гүйцэтгүүлэгч” гэх/, нөгөө талаас Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн /регистрийн дугаар:8000204/, түүнийг төлөөлж тэргүүн Л.Дондог /цаашид “үүрэг гүйцэтгэгч” гэх/ нар /хамтад нь “талууд” гэх/ доорх нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг /цаашид “Гэрээ” гэх/ байгуулав.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 2.1 Гэрээгээр үүрэг гүйцэтгэгч нь дор дурдсан төрийн байгууллагын зарим чиг үүргийг иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай, чанартай гүйцэтгэнэ.
- 2.1.1 Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 2.1.2 Аж ахуйн нэгж, байгууллагуудад хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэл хөтлөх программ хангамж нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Монгол улсын холбогдох заавар журамд нийцсэн эсэх талаарх мэдээллээр хангах;
- 2.1.3 Нягтлан бодох бүртгэх хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжид хяналт тавих;
- 2.1.4 Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн хэрэглээний чиглэлээр зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх;
- 2.1.5 Ажил эрхэлж байгаа нягтлан бодогчдын мэдээллийн санг бүрдүүлж, тэдгээрийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг сайжруулах;
- 2.2 Талууд Гэрээний 2.1-д заасан үйл ажиллагааг хамтран зохион байгуулна.
- 2.3 Гэрээний 2.1-д заасан чиг үүргийн хүрээнд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг үүрэг гүйцэтгэгчийн саналыг үндэслэн тухайн жилийн 2 дугаар сарын 15-ны дотор Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар батална.

ГУРАВ. ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа нь холбогдох хууль болон энэ гэрээнд заасны дагуу явагдаж байгаа эсэх талаар дүгнэлт гарган, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хянан, арга хэмжээ авч, шийдвэр гаргах эрхтэй.

- 3.2 Үүрэг гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нэг талын санаачилгаар энэхүү гэрээг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь хүчингүй болгох бүрэн эрхтэй.
- 3.3 Үүрэг гүйцэтгэгчийн Гэрээнд тусгасан үүргээ гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг Гэрээнд хавсаргаж, гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.4 Үүрэг гүйцэтгэгчийн Гэрээнд тусгасан үүргээ гүйцэтгэхэд бодлогын дэмжлэг үзүүлж болно.
- 3.5 Гэрээний 3.3-т заасан ажлын төлөвлөгөө нь гэрээний нэг хэсэг болно.

ДӨРӨВ. ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны зохион байгуулалтад үүрэг гүйцэтгүүлэгчээс туслалцаа, дэмжлэг авах эрхтэй.
- 4.2 Гэрээний 2.1-д заасан чиг үүргийг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэж, үүрэг гүйцэтгүүлэгчид тайлагнах үүрэгтэй.
- 4.3 Гэрээ болон ажлын төлөвлөгөөний биелэлтийг үүрэг гүйцэтгүүлэгчид жил бүрийн тухайн оны 12 дугаар сарын 5-ны өдрийн дотор бичгээр ирүүлнэ.

ТАВ. ТАЛУУДЫН НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гэрээний нөгөө талаас шаардах эрхтэй.
- 5.2 Гэрээний биелэлтийг хангахад технологийн эрх зүйн орчинд өөрчлөлт шинэчлэлт гарсан тохиолдолд хамтын ажиллагааг тэдгээрт нийцүүлэх талаар санаачилга гаргаж ажиллана.
- 5.3 Талууд Гэрээний үүргийн биелэлтийг тухайн жилийн 12 дугаар сарын 5-ны өдрийн дотор гаргаж 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор дүгнэнэ.

ЗУРГАА. ДЭМЖЛЭГ

- 6.1 Үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчийг Гэрээний 2.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүрэг гүйцэтгэгчид дараах дэмжлэг үзүүлж болно.
 - 6.1.1 Гадаад, дотоодын сургалт, техникийн уулзалтуудад гүйцэтгэгчийн зардлаар оролцуулах;
 - 6.1.2 “Мэргэжлийн нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтэд хяналт тавих, ажил эрхэлж байгаа нягтлан бодогчдыг бүртгэж, мэдээллийн санг бүрдүүлэх, тэдгээрийн мэргэжлийн хөгжлийг сайжруулахад бодлогын дэмжлэг үзүүлэх;

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

- 7.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад холбогдох хууль тогтоомж зөрчигдсөн байх болзошгүй тохиолдолд илэрсэн зөрчил дутагдлыг харилцан мэдээлэх, зөрчлийг арилгах талаар хамтран ажиллана.
- 7.2 Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тал хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан гарах аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 8.2 Хэрэв талууд харилцан зөвшилцөж чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1 Гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2 Гэрээг 2 хувь үйлдэж гүйцэтгэгч тал 1 хувь, гүйцэтгүүлэгч тал 1 хувийг тус тус хадгалах бөгөөд эх хувь тус бүх хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 9.3 Талууд энэхүү Гэрээгээр хүлээх эрх үүргээ бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусад шилжүүлэхгүй.
- 9.4 Гэрээний талуудын үйл ажиллагааны чиглэл, нэр, удирдлага зохион байгуулалтад аливаа өөрчлөлт орсон тохиолдолд тухайн үйл ажиллагааг залгамжлан хэрэгжүүлэх байгууллага нь Гэрээний эрх, үүргийг шууд хүлээн авах ба Гэрээний үүрэг заавал биелэгдэх шинжтэй байна.
- 9.5 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр хийх бөгөөд Гэрээнд оролцогч бүх Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр гэж тооцогдоно. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Гэрээний нэгэн адил хүчинтэй байж, түүний салшгүй хэсэг байна.
- 9.6 Гэрээгээр зохицуулаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор зохицуулж, түүнийг удирдлага болгоно.
- 9.7 Гэрээ нь гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 9.8 Гэрээг шинэчлэн байгуулсантай холбогдуулан талуудын хооронд 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан 22 дугаартай гэрээг дүгнэж дуусгавар болгов.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


САНГИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ:

САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН

МОНГОЛЫН НИЯТЛАН БОДОХ
БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭЛЭНГ ТӨЛӨӨЛЖ:

ТЭРГҮҮН
Л.ДОНДОГ

БАТЛАВ: САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ
 БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН
 АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


 Б.БОЛОРМАА

МОНГОЛЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ГЭРЭЭГЭЭР
 ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны 3-р сарын 1-ний өдөр

Гэрээний заалт	Үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх үр дүн
2.1.1.Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг боловсруулан батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;	1.Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн асуудлаар ирсэн мэдээлэл хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар СЯ-д мэдээлэх	Жилийн турш	Мэргэжлийн нягтлан бодогчид ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьсан байна.
	2.Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс дүрмийн талаар төгсөгч оюутнуудад мэдээлэл хийх	1-2 дугаар улиралд	Мэргэжилтнүүдэд ёс зүйн дүрмийн талаар мэдээлэл өгсөн байна.
2.1.2.Аж ахуйн нэгж, байгууллагуудад хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэл хөтлөх программ хангамж нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Монгол Улсын холбогдох заавар журамд нийцсэн эсэх талаарх мэдээллээр хангах;	3.Аж ахуйн нэгжид зориулж шинээр хөгжүүлсэн НББ-ийн программд үнэлгээ өгөх ажлыг хийх 4.НББ-ийн программ зохиогч компаниудаас боловсруулж Төсөвт байгууллагуудад шинээр суурилуулах программуудад үнэлгээ өгөх	2 болон 4 дүгээр улиралд	Нягтлан бодох бүртгэлийн бүх программыг бүртгэж хяналт тавьсан байна.
	5.НББ-ийн программ зохиогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх: а.НББ-ийн программд тавигдах шаардлага, нэгдмэл загварт шилжих талаар зөвлөлдөх	2 дүгээр улиралд	НББ-ийн программын чанарыг сайжруулах талаар зөвлөгөө өгсөн байна.
2.1.3.Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программд хангамжид хяналт тавих;	6.НББ-ийн программ зохиогчдын зөвлөгөөнийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	2 дугаар улирал	НББ-ийн программын талаар гарч байгаа зөрчил дутагдлыг арилгах
	7. Хүрээлэнгийн өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг газар дээр нь үзэж танилцах	3 болон 4 дүгээр улиралд	НББ-ийн программын иж бүрдлийг хангах

<p>2.1.4.Нягтлан бодох бүртгэлийн программд хангамжийн хэрэглээний чиглэлээр зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх.</p>	<p>8.НББ-ийн программд тавигдах нийтлэг шаардлага /стандарт/ баримт бичгийн төсөл боловсруулж СЯ-д хүргүүлэх.</p>	<p>3 болон 4 дүгээр улиралд</p>	<p>Программд тавигдах нийтлэг шаардлагыг боловсруулсан байна.</p>
<p>2.1.5.Ажил эрхэлж байгаа мэргэжлийн нягтлан бодогчдын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх.</p>	<p>9.Ажил эрхэлж байгаа нягтлан бодогчдыг бүртгэх, мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.</p>	<p>Жилийн туршид</p>	<p>Ажил эрхэлж байгаа нягтлан бодогчдын бүртгэл мэдээллийн санг бий болгосон байна.</p>